



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 3 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар
хот

Тогтоол хүчингүй болгох тухай

Төмөр замын тээврийн тухай хуулийн 9.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6, Улсын Их Хурлын 2014 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нүүрсний экспортыг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 299 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл, “Хамтарсан компани байгуулах тухай” Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 91 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн боомтын төмөр зам барих зорилгоор байгуулсан “Гашуунсухайтын төмөр зам” ХХК-д оруулсан хувь хөрөнгөө татан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (У.Бямбасүрэн)-д даалгасугай.

3. Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн боомтын төмөр замын төсөлд “Гашуунсухайтын төмөр зам” ХХК-иас оруулсан хөрөнгө оруулалтад хөндлөнгийн аудит хийлгэх асуудлыг шийдвэрлүүлэхийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (У.Бямбасүрэн)-д даалгасугай.

4. Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг үндэслэн Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн боомтын төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд оруулах нийт хөрөнгө оруулалтад нь багтаан тооцуулах талаар хөрөнгө оруулахыг сонирхож байгаа этгээдтэй хэлэлцээ хийж тохиролцохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай.

5. Энэ тогтоолын 3 дугаар зүйлд заасны дагуу хөндлөнгийн аудит хийлгэхэд шаардагдах зардлыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгах замаар шийдвэрлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн хөгжлийн сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Д.ГАНБАТ